



СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫН ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№62 /506/

2023.04.17

Цаг үе, үйл явдал

БҮГД НАЙРАМДАХ ПОЛЬШ УЛСААС МОНГОЛ УЛСАД СУУГАА ЭЛЧИН САЙДЫГ ХҮЛЭЭН АВЧ УУЛЗАВ



Монгол Улсын Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга бригадын генерал С.Ганбямбын хүсэлтээр Бүгд Найрамдах Польш Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайд Кшиштоф Бойког 2023 оны 4 дүгээр сарын 13-ны өдөр хүлээн авч уулзаж, хамтын ажиллагааг хөгжүүлэх талаар санал солилцлоо.

Дэд хурандаа З.АЛТАНЗОРИГ

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-5	5

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
39	27

ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD	3,487	3,494
EUR	3,850	3,880
CNY	512	515
RUB	42,60	42,90
JPY	26.35	26.70
KRW	2.67	2.69

ЗУРХАЙ



2023.04.17 /ДАВАА ГАРАГ/
БИЛГИЙН ТООЛЛЫН 27

**ХАВРЫН ДУНД ХӨХӨГЧИН
ТУУЛАЙ САР
НАЙМАН ЦАГААН МЭНГЭТЭЙ
ХӨХӨГЧИН МОГОЙ ӨДӨР**

ЭСЭЭ БИЧЛЭГИЙН УРАЛДААНД ТЭРГҮҮЛСЭН ДАЙЧИД ШАГНАЛАА ГАРДАВ



"Миний хааж буй цэргийн алба" сэдэвт эсээ бичлэгийн уралдаанд эхний 10 байрт шалгарсан хугацаат цэргийн алба хаагчдын шагнал гардуулах ёслолын ажиллагааг энэ сарын 14-ний өдөр Отгонтэнгэр их сургуульд зохион байгуулав.

Зэвсэгт хүчний Жанжин штаб, Хил хамгаалах Ерөнхий газар, "Монгол цэргийн нэгдсэн холбоо" төрийн бус байгууллага, Отгонтэнгэр их сургууль хамтран Зэвсэгт хүчин, Хил хамгаалах байгууллагад цэргийн гэрээт болон хугацаат алба хааж буй түүрүүч, байлдагч нарын дунд энэхүү эсээ бичлэгийн уралдааныг зарлаж дүгнэсэн юм.

Шагнал гардуулах ёслолд МЦНХ-ны Ажлын албаны дарга бэлтгэл хурандаа Ж.Ванчинсүрэн, МЦНХ-ны ажлын албаны

ажилтнууд, Отгонтэнгэр их сургуулийн захирал, доктор, дэд профессор Н.Энхзаяа, дэд захирал доктор Б.Одгэрэл, Гавьяат багш Б.Галиндэв нар болон уралдаанд эхний байр эзэлсэн хугацаат цэргийн алба хаагчид, тэдний ар гэрийн төлөөлөл оролцлоо. Мөн МЦНХ-ны Говь-Алтай, Дорнод, Дундговь аймгийн салбар холбоодын дарга, ажилтнууд, хөдөө, орон нутгаас байр эзэлсэн түүрүүч, байлдагч нарын анги, хамт олон, гэр бүлийн төлөөлөл цахимаар оролцлоо.

Нээлтийн ёслолын үеэр МЦНХ-ны Ажлын албаны дарга бэлтгэл хурандаа Ж.Ванчинсүрэн хэлсэн үгэндээ "Монгол цэргийн нэгдсэн холбоо нь хүүхэд, залуучууд, иргэдэд эх оронч үзлийг төлөвшүүлэх чиглэлээр олон талт ажлыг хэрэгжүүлж буйн дотор энэ удаагийн


эсээ бичлэгийн уралдааныг цэргийн гэрээт болон хугацаат алба хаагчдын дунд амжилттай явууллаа. Уралдаанд Зэвсэгт хүчний 24 нэгтгэл, ангиас 233, Хилийн цэргийн 10 ангиас 130 түүрүүч, байлдагч хамрагдаж дүнгээ гаргасан" гэдгийг онцлов.

Мөн Отгонтэнгэр их сургуулийн захирал, доктор, дэд профессор Н.Энхзаяа "Тус сургууль "Монгол цэргийн нэгдсэн холбоо" төрийн бус байгууллагатай нягт хамтран ажилладаг. Бид Ерөнхий боловсролын сургуулиудын ахлах ангийн сурагчдын дунд эсээ бичлэгийн уралдааныг зохион байгуулж ирсэн туршлагадаа тулгуурлан энэ жил цэргүүдийнхээ дунд уг уралдааныг амжилттай явууллаа. Уг уралдааныг зохион байгуулахад Гавьяат багш Б.Галиндэвийн оруулсан хувь нэмэр их гэдгийг онцолмоор байна. Иргэний цэргийн үүргээ үнэнчээр биелүүлж, эх орныхоо эрх чөлөө, тусгаар тогтнолыг батлан хамгаалах үйл хэрэгт зүтгэж, эх орныхоо торгон хилийг манаж буй цэргийн алба хаагч Та бүхэндээ баярлалаа гэдгээ илэрхийлье. Уралдаанд идэвхтэй оролцсон Та бүхэнд баяр хүргэе" хэмээсэн юм.

Уралдааны нэгдсэн дүнгээр тэргүүн байрт шалгарсан Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн байлдагч М.Алтанбагана Талархал, 400 мянган төгрөг, Отгонтэнгэр их сургуульд эхний жил үнэгүй суралцах эрхийн бичиг, дэд байр эзэлсэн Хилийн 0214 дүгээр ангийн байлдагч Д.Ууганбаяр Талархал, 200 мянган төгрөг, Отгонтэнгэр их сургуульд 70 хувийн хөнгөлөлттэй суралцах эрхийн бичиг, гутгаар байрт шалгарсан Хилийн 0198 дугаар ангийн байлдагч Ч.Чингүүн Талархал, 100 мянган төгрөг, Отгонтэнгэр их сургуульд 50 хувийн хөнгөлөлттэй суралцах эрхийн бичгийн эзэн болов.

Тэрчлэн тусгай байр эзэлсэн Зэвсэгт хүчний 017, 120, 327, 336 дугаар ангийн Б.Төгөлдөр, Б.Билгүүнбаяр, А.Билгүүн, Д.Билгүүдэй, Хилийн 0198 дугаар ангийн байлдагч Ү.Дорждэрэм, Б.Төмөрсүх, нарыг Отгонтэнгэр их сургуульд 50 хувийн хөнгөлөлттэй суралцах эрхийн бичгээр шагнасан юм.

Хурандаа
Б.ОТГОНБАЯР



КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 685,679,893

Эдгэрсэн

Нийт: 658,410,643

Нас барсан

Нийт: 6,842,570

Цахим шууданд

ИХ ГОВИЙН ГАРНИЗОНООС ЭХНИЙ 10-Т ШАЛГАРАВ



оролцлоо.

Байлдагч А.Билгүүн сэтгэгдлээ хуваалцахдаа "Би Дархан-Уул аймгаас "Их говийн гарнизон" буюу цэргийнхний ярьдгаар хэрийн академид томилогдон хугацаат цэргийн алба хааж байна.

Домог, түүхт 6 дугаар морьт дивизээс улбаатай 91 жилийн буурал түүхтэй энэхүү ангид алба хааж байгаагаараа бахархаж байна. Энэ бахархал маань миний насан туршийнх байх болно гэдэгт огтхон ч эргэлзэхгүй байгаа. Алба хаах хугацаандаа цэргийн эрдэмд шамдан боловсрохын хажуугаар бидний чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд анхаарал хандуулж төрөл бүрийн уралдаан тэмцээнийг зохин байгуулдаг соёл хүмүүжлийн офицерууддаа баярлаж явдгаа уламжлахад таатай байна.

Энэхүү эсээ бичлэгийн уралдаанд алба хааж буй орчин нөхцөл, өөрт төрж буй бахархам сэтгэгдлээ л нэмэлт хачиргүй бичиж, "Отгон тэнгэр" их сургуульд хүссэн ангидаа эхний нэг жил төлбөрийн 50 хувийн хөнгөлөлттэй сурах батламж болон бусад гарын билгээр шагнагдсандаа маш их баяртай байна. Мөн Дорноговь аймгийн төв музейг энэ үеэр үзэж, түүх дурсгалын өлгий нутагт алба хааж байгаагаа улам бахархаж байлаа" гэсэн юм.

Ахмад А.АЛТАНХУЯГ

Монгол цэргийн нэгдсэн холбоо, "Отгон тэнгэр" их сургууль хамтран Зэвсэгт хүчин, Хилхамгаалах байгууллагад цэргийн гэрээт болон хугацаат алба хааж буй түрүүч, байлдагч нарын дунд зарласан "Миний хааж буй цэргийн алба" сэдэвт эсээ бичлэгийн уралдаанд Зэвсэгт хүчний 24 нэгтгэл, ангиас 233, Хилийн цэргийн 10 ангиас 130 түрүүч, байлдагч нар оролцсоноос Жанжин Д.Сүхбаатарын нэрэмжит Байлдааны гавьяаны Улаан тугийн одонт Зэвсэгт хүчний 336 дугаар ангид хугацаат цэргийн алба хааж буй байлдагч А.Билгүүн, Д.Билгүүдий

нар 6, 9 дүгээр байрт шалгарч шилдэг аравт багтав.

Эсээ бичлэгийн шилдэг 10-т шалгарсан дайчдад шагнал гардуулах арга хэмжээнд ангийн захирагч хурандаа А.Болдбаатар, Дорноговь аймаг дахь Монгол цэргийн нэгдсэн холбооны нарийн бичгийн дарга Б.Баасанжав, ахлах мэргэжилтэн Б.Батчөдөр, аймгийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх Цэргийн штабын олон нийттэй харилцах, сургалтын офицер хошууч Б.Ууганбаасан, ахмад дайчин Л.Бумцэнд болон ангийн соёл хүмүүжлийн офицерууд



"ЗУУН ЖИЛИЙН ДУУЛАЛ" АЯЛАН ТОГЛОЛТЫГ МӨРДЭС НЭГТ НӨХДӨДӨӨ ӨРГӨН БАРИЛАА



гээд олон үзүүлбэрээр бэлэг барилаа.

Ташрамд дурдахад, үндэсний соёл урлагийг нийтэд сурталчлан таниулах, ардын уламжлалт ёс заншлыг түгээн дэлгэрүүлэх зорилготойгоор төрийн



цэргийн 30 байгууллагын 300 гаруй цэргийн алба хаагчийн дунд явагдсан "Цагаан сар-Монгол түмний уламжлалт их баяр-2023" тэмцээнд "Зуун жилийн дуулал" тоглолтын авьяаслаг цэргийн алба хаагчид тэргүүн байр эзэлсэн билээ. Аялан тоглолт өргөн баригчдын 8 нь хугацаат цэргийн алба хаагч юм.

Дэд хурандаа Д.ДОЛГОРЖАВ

Энэ жил 100 жилийнхээ буурал түүхийг бичиж буй эгнээнээсээ 10 баатар төрүүлсэн Маршал Х.Чойбалсангийн нэрэмжит Сүхбаатарын болон Байлдааны гавьяаны Улаан тугийн одонт Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлийнхэн ойн хүрээнд цэрэг-эх оронч үзлийг түгээн дэлгэрүүлэх, иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх, Монгол бахархлыг төлөвшүүлэх олон талт арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж байна.

Үүний нэг нь нэгтгэлийн авьяаслаг алба хаагчдын "Зуун жилийн дуулал" аялан тоглолт юм. "Зуун жилийн дуулал" тоглолтоороо Зэвсэгт хүчний 345 дугаар нэгтгэл, Зэвсэгт хүчний 119, 013, 150, 353, 014, 350, 337 дугаар ангиудад саатаж, язгуур урлаг, үлээвэр найрал хөгжим болон цахилгаан хөгжмийн "Оч" хамтлаг, цэрэг дайчдын тухай дуу, бүжиг, хөгжим



ГАЛЫН АЮУЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ СУРГАЛТ ЯВУУЛАВ



ЗХЖШ-ын Үлгэр жишээ Үлээвэр найрал хөгжмийн тооны бус бүрэлдэхүүнтэй аюулаас урьдчилан сургалтыг ангийн байрлалд зохион байгууллаа.

Тус сургалтын зорилго нь гарч болзошгүй галын аюулаас урьдчилан сэргийлэх, галын аюулгүй байдлыг хангах, гал унтраах анхан шатны багаж хэрэгсэл, бодис, материалыг зөв ашиглаж сурах арга ажиллагаанд сурган дадлагдахуулахад чиглэгдсэн

юм. Ийнхүү Монгол Улсын "Гамшгаас хамгаалах тухай хууль", "Галын аюулгүй байдлын тухай хууль", "Зэвсэгт хүчний галын аюулгүй байдлын дүрэм"-ийн хэрэгжилт, тэдгээртэй нийцүүлэн гаргасан эрх зүйн баримт бичгүүдийн хүрээнд УБТЗ-ын цэрэгжүүлсэн хамгаалалт, онцгой байдлын албаны гал унтраах хэсэгтэй хамтран ажиллах санамж бичгийн дагуу галын аюулгүй байдлын сургалтыг онол, дадлагаар зохион байгуулсан.

Дэслэгч Б.АМГАЛАНБОЛД



АХЛАГЧ НАР "ЗАНГИАГУЙ УУЛЗАЛТ"-ЫГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



Зэвсэгт хүчний 310 дугаар ангийн "Ахлагчийн зөвлөл"-өөс ахлагчийн бүрэлдэхүүнийхээ дунд "Зангиагүй уулзалт" чөлөөт ярилцлагыг зохион байгуулж, харилцан ярилцлаа.

Энэхүү уулзалтад ангийн удирдлагуудыг оролцуулсан бөгөөд ахлагч нарт тулгамдаж байгаа асуудал, түүний шийдэл гарц, албаны үлгэрлэл манлайлал, бүтээлч санаачилга, идэвх оролцоо, үүрэг биелүүлэлт, ёс зүй, сахилга бат, гэр бүл дэх халамж зэрэг олон чухал асуудлаар ярилцсан юм.

Ахлагч нар "Дүрэмт

хувцасгүйгээр буюу хүний ёсоор ажил алба илүү эрч хүчтэй, үр бүтээлтэй, сахилга баттай явуулах талаар ярилцах нь таалагдлаа. Алба хаагчдын ажлын идэвхийг нэмэгдүүлж, хамт олонч нөхөрсөг уур амьсгалыг бэхжүүлэхэд энэ уулзалт чухал боллоо" хэмээж байсан юм.

Мөн энэхүү уулзалтын эхэнд доктор Д.Отгончимэг "Сурахайд суралцахуй" сэдвээр лекц уншиж, сурахад хэзээ ч оройддоггүй, сурсан бүхэн амьдралд заавал хэрэг болдгийг онцолсон юм.

Тэргүүн ахлагч Б.ЛХАГВАБААТАР

